

УСНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| А/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэл, байдлаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|-----------------|--------------------|---|---|--|---|-------------------|
| | | Хэмжээ, сая.төг | Төсвийн эх үүсвэр | | | | | |
| УСНЫ ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу нийгэм эдийн засгийн өсөн нэмэгдэх эрэлт хэрэгцээг чанарын шаардлага хангасан баталгаатай, хүртээмжтэй усаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлж, цахим засаглалыг нэвтрүүлнэ. | | | | | | | | |
| НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ | | | | | | | | |
| Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.5.1.7, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 6.3.9, "Шинэ сэргэлтийн бодлого" хөтөлбөрийн 5.2.1, 6.3.1, 6.3.3, 6.3.8, 6.3.10, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.3.2, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.3, 5.1.6, 5.1.9, 5.1.11, Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилт 4, зорилт 23, Агентагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн 2.3.2.3 | | | | | | | | |
| Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилт 1.Ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул хийж, нөөцийг баталгаажуулан нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт 1: Ус хангамжийн эх үүсвэрийн эрэл хайгуул хийж, нөөцийг баталгаажуулан нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1. Гидрогеологийн дунд масштабын (1:200000) зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтоох | 200.0 | Улсын төсөв | Гидрогеологийн дунд масштабын зураглал хийсэн газар нутгийн эзлэх хувь | 17.3% | Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлын тайланг хүлээн авч, зураглал хийсэн газар нутгийг 17.6%-д хүргэсэн байна. | "Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтоох" зорилтын хүрээнд 2024 онд Дорноговь аймгийн Өргөн, Алтанширээ, Иххэт, Дэлгэрэх сумдын нутаг (L-49-XXI (бүтэн), L-49-XXVII (хагас) хавтгай)-т 1:200000 масштабтай зураглалын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийсэн. Үнэлгээний хороог Усны газрын даргын 2024 оны А/15 дугаар тушаалаар байгуулсан. Зөвлөх үйлчилгээний ажлыг 2024.04.05 болон 2024.05.06-ны өдөр зарлаж, 2024.06.19-ний өдөр гүйцэтгэчийг шалгаруулсан бөгөөд "Дунар-Од" ХХК шалгарч, 2024.06.26-ны өдөр УГ/20240101008 дугаартай гэрээ байгуулан ажилласан. Тус ажлын гүйцэтгэлийн тайланг Усны газарт ирүүлсэн бөгөөд ажлын үр дүнд гидрогеологийн дунд масштабын зураглал хийгдсэн газар нутгийн хэмжээг 17.8%-д хүргэсэн. | 100 |
| 2 | Арга хэмжээ 1.2.Говь-Алтай аймгийн Төгрөг сумын төвийн ус хангамжийг нөөцийг тогтоох эрэл хайгуулын ажлыг хэрэгжүүлэх | 600.0 | Улсын төсөв | -Ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгаа хийсэн сумдын тоо -Баталгаат ундны усвар хангагдсан хүн амын тоо. | - 3 сум (Булган аймгийн Дашинчилэн, Өмнөговь аймгийн Манлай, Говь-Алтай аймгийн Халиун сум) - Хүн амын тоо 8,156 | Газрын доорх усны хайгуул, судалгааны хэзэрийн ажлын явцад хяналт тавьж, судалгааны тайланг хүлээн авч, нөөцийг баталгаажуулж, Төгрөг сумын ундны усны эх үүсвэртэй болгож, хүн амын тоог 1991-ээр нэмэгдүүлнэ | 2024 онд Говь-Алтай аймгийн Төгрөг сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог Усны газрын даргын 2024 оны А/16 дугаар тушаалаар байгуулсан. Зөвлөх үйлчилгээний ажлыг 2024.04.08-ны өдөр зарлаж, 2024.05.14-ний өдөр гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан бөгөөд "Таширын хүрээ" ХХК шалгарч, 2024.05.21-ний өдөр УГ/20240101007 дугаартай гэрээ байгуулсан. "Шинжээч томилох тухай" Усны газрын даргын 2024 оны А/88 дугаар тушаалаар тус судалгааны хэзэрийн ажлын явцад 2024.06.13-17-ны өдөр хяналт тавьж, ажлын гүйцэтгэлтэй танилцаж, холбогдох санал, зөвлөмж өгч ажилласан. | 90 |
| 3 | Арга хэмжээ 1.3.Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавих, нөөцийг баталгаажуулах. | 954.8 | Орон нутгийн төсөв | Төвлөрсөн эх үүсвэрт ашиглах боломжит усны нөөцийн хэмжээ м3/хон | 4,060.8 м ³ /хон | Эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайланг хүлээн авч, нөөцийг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна. | "Шинжээч томилох тухай" Усны газрын даргын 2024 оны өдрийн А/70 дугаар тушаалаар баталсан шинжээчид "Өмнөговь аймгийн Даланзадгад сумын унд ахуйн усны 2 дугаар эх үүсвэрийн талбайд явуулах газрын доорх усны эрэл хайгуулын судалгаа"-ны ажлын хэзэрийн ажлын явцад хяналт тавьж, санал, зөвлөмж өгч ажилласан. "Шүүмжлэгч томилох тухай" Усны газрын даргын 2024 оны А/149 дугаар тушаалаар судалгааны ажлын үр дүнгийн тайланг шүүмжлэгч томилж, зөвлөмж, дүгнэлт өгч холбогдох засварыг хийсэн бөгөөд Усны нөөцийн зөвлөлийн 2024 оны 2-р хуралдаанаар хэлэлцүүлэн нөөцийг батласан | 100 |
| 4 | Арга хэмжээ 1.4."Шинэ хархорум" хотын хүн амын унд ахуйн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, гүйцэтгэлд хяналт тавих. | 5,000.0 | Улсын төсөв | Газрын доорх усны эрэл-хайгуулын ажлын двалгаарын хэрэгжилтийн хувь | - | Газрын доорх усны хайгуул, судалгааны хэзэрийн ажлын явцад хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, судалгааны тайланг хүлээн авч, нөөцийг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна. | "Шинжээчдийн баг томилох тухай" Усны газрын даргын 2024 оны А/108 дугаар тушаалаар баталсан шинжээчдийн баг ""Шинэ Хархорум" хотын хүн амын унд ахуйн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажил"-ийн хэзэрийн ажлын явцад хяналт тавьж, санал, зөвлөмж өгч ажилласан. Судалгааны ажлын газрын доорх усны эрлийн судалгааны үр дүнг Усны нөөцийн зөвлөлийн 2024 оны 2 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн зөвлөлийн гишүүдээс холбогдох санал, зөвлөмж өгсөн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|-----|-------------|--------------------------|---|---|--|----|
| 5 | Арга хэмжээ 1.5.Усны нөөцийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлуулж, Усны нөөцийн зөвлөлийн хуралдааны зохион байгуулах. | 5.0 | Улсын төсөв | Зөвлөлийн хуралдааны тоо | 2 | Усны нөөцийн зөвлөлийн хуралдааны 4-өөс доошгүй удаа зохион байгуулсан байна. | Усны нөөцийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг БОУАӨ сайдын 2024 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/774 тушаалаар шинэчлэн баталсан. Усны нөөцийн зөвлөлийн 2024 оны 1 дүгээр хуралдааныг 2024.03.12-нд, 2 дугаар хуралдааныг 2024.11.22-нд зохион байгуулсан бөгөөд эхний хуралдаанаар 1 газрын доорх усны нөөц тогтоох судалгааны ажлын үр дүнгийн тайлан, 4 төслийн ажлын даалгаврыг хэлэлцэж, холбогдох санал, зөвлөмж өгсөн. Хоёрдугаар хуралдаанаар 5 газрын доорх усны нөөц тогтоох судалгааны ажлын үр дүнгийн тайлан, 2 усан цахилгаан станцын ТЭЗҮ, судалгааны үр дүн, 1 гадаргын усны судалгааны ажлын үр дүнг хэлэлцэж, холбогдох санал, зөвлөмж өгсөн. | 90 |
|---|---|-----|-------------|--------------------------|---|---|--|----|

Зорилт 2: Аж үйлдвэр, уул уурхай, хөдөө аж ахуйн болон бусад салбаруудын усны эрэлт хэрэгцээг тогтвортой хангана.

| | | | | | | | | |
|---|---|---------|---------------|---|----|--|---|-----|
| 6 | Арга хэмжээ 2.1.Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гүний хоолойн газрын доорх усны ордын ашиглалтын хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавих. | 3,500.0 | Хувийн хэвшил | Газрын доорх усны эрэл-хайгуулын ажлын даалгаврын хэрэгжилт, хувь | 20 | Газрын доорх усны хайгуул, судалгааны хээрийн ажлын явц, үр дүнг Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлж, усны нөөцийг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна. | "Шинжээчдийн баг томилох тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.05.01-ний өдрийн А/173 дугаар тушаалаар баталсан шинжээчдийн баг нь Усны газрын даргын 2023.01.24-ний өдөр баталсан ажлын даалгаврын дагуу "Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гүний хоолойн газрын доорх усны ордын ашиглалтын хайгуулын судалгаа"-ны ажлын хээрийн ажлын явцад 2024.05.15-16, 2024.06.26-27-нд 2 удаа хяналт тавьж, санал, зөвлөмж өгч ажилласан. Усны газрын 2024.05.30-ны 01/720 албан тоотоор шинжээчдийн багийн дүгнэлтийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга болон захиалагч "Оюутолгой" ХХК, гүйцэтгэгч "Охь-Ус" ХХК-д хүргүүлсэн. Судалгааны ажлын суурин боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна. | 100 |
|---|---|---------|---------------|---|----|--|---|-----|

| | | | | | | | | |
|---|---|---|---------------|--|---|--|---|-----|
| 7 | Арга хэмжээ 2.2.Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр гүйцэтгэх газрын доорх усны хайгуул судалгааны ажилд хяналт тавьж, ашиглах боломжит нөөцийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах. | - | Хувийн хэвшил | Хувийн хөрөнгөөр хийсэн газрын доорх усны хайгуул судалгааны ажлын тоо | 6 | Газрын доорх усны хайгуул, ажлын үр дүнгийн судалгааны тайланг хүлээн авч, нөөцийг баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байна. | 2024 онд нийт 8 аж, ахуй нэгж байгууллагын газрын доорх усны нөөц тогтоох эрэл-хайгуулын судалгааны ажлын даалгаврыг баталж, 3 судалгааны ажлын хээрийн явцад хяналт тавьж, санал, зөвлөмж өгч ажилласан. 1. "Оюут улаан" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Харматгайн үндсэн ордын технологийн ус хангамжийн зориулалттай "Загийн усны худа"-ийн газрын доорх усны ордын дэвсгэр талбайн баруун өмнөд болон зүүн жигүүрийн бусад явуулах гүйцээх хайгуулын гидрогеологийн судалгааны ажил; 2. "Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт барихаар төлөвлөж буй 450МВт хүчин чадалтай "Тавантолгой дулааны цахилгаан станц"-ын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажил; 3. "Шарын гол эрчим хүч" ХХК-ийн хөрөнгө оруулалтаар "Шарын голын нүүрсний уурхайг түшиглэн барихаар төлөвлөж буй цахилгаан станцын технологийн ус хангамжийн нэмэлт эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл хайгуулын судалгааны ажил"-ын хээрийн явцад хяналт тавьж, санал, зөвлөмж өгч ажилласан. Усны нөөцийн зөвлөлийн 2024 оны 2-р хурлаар нийт 4 аж, ахуй нэгж байгууллагын ус хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны ордын нөөцийг хэлэлцэж, баталсан. | 100 |
|---|---|---|---------------|--|---|--|---|-----|

Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилт 2. Усны нөөцөд тулгуурласан хамгаалалт, ашиглалтын менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангаж усны нөөцийг бохирдлоос сэргийлнэ.

Зорилт 3: Усны нөөцийг хамгаалах, бохирдож хомсдохоос сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

| | | | | | | | | |
|---|--|------|-----------------|----------------------------------|---|---|---|-----|
| 8 | Арга хэмжээ 3.1.Сав газрын УННМТ-г батлагдсан аргачлалын дагуу боловсруулах ажлыг зохион байгуулах мэргэжил арга зүйгээр хангах. | | Төсөл, хөтөлбөр | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 2 | 29 сав газрын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, 2-аас доошгүй сав газрын УННМТ-ний төслийг батлуулахаар БОУАӨЯ-нд хүргүүлсэн байна. | <p>Тайланг хугацаанд сав газрын УННМТ-ний хэрэгжилтийн хугацаа дууссан дараах 2 сав газрын УННМТ-ийг боловсруулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>1. Туул голын сав газрын УННМ-ийн төлөвлөгөөг боловсруулах ажлын даалгаврыг БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар 2024.04.18-ны өдөр батлуулсан. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн дэргэд хэрэгжиж буй "Уур амьсгалыг хамгаалах стратегийн бодлогын хэлэлцүүлэг, мэдлэгийн менежмент" (DIAPOL-CE) төсөлтэй хамтран батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг 2024.04.01-2024.05.15-ны хооронд зохион байгуулсан. Уг сонгон шалгаруулалтаар "Престиж инженеринг" ХХК шалгарч ТГСГУННМТ-г боловсруулах гэрээг DIAPOL-CE төсөлтэй 2024.05.15-ны өдөр байгуулсан.</p> <p>Гэрээ албаخرсны дагуу ТГСГЗ гүйцэтгэгч байгууллага болох "Престиж инженеринг" ХХК-тай 2024.06.03-ны өдөр эхний уулзалтыг зохион байгуулж, мэдээ, мэдээлэл цуглуулах болон хэзэрийн судалгааны ажлыг гүйцэтгэх нарийвчилсан график төлөвлөгөөг хэлэлцэж, баталсан.</p> <p>2. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн газар хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь" төслөөс 2024 онд Ховд аймгийн нутаг дэвсгэрт хамаарах 2 сав газрын УННМ-ийн төлөвлөгөөнд уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдлаар уялдуулан шинэчлэн боловсруулж батлуулах зөвлөх үйлчилгээг зарлаж, гүйцэтгэгчээр "Престиж Инженеринг" ХХК шалгарсан. Дээрх ажлын хүрээнд Хар нуур-Ховд голын голын сав газар, Үвэн-Бодонч голын сав газар, газруудын экосистем, усны нөөцөд уур амьсгалын өөрчлөлтөөс үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөө, эрсдэлийн менежментийг боловсруулж, тухайн сав газрын усны нөөцийн менежментийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлэн ажиллаж байна.</p> <p>Байгаль орчин, аялал жуулчлалын Сөдийн 2024.07.05-ны А/567 тушаалаар Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газар, Булган голын сав газар, Увс нуур-Тасгийн голын сав газар, Галба-Өөш-Долоодын говийн сав газар, Мэнэнгийн талын сав газар, Онон голын сав газар, Умард говийн гүвээт-Халхын дундэд талын сав газар, Хэрлэн голын сав газрын менежментийг төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> | 100 |
| 9 | Арга хэмжээ 3.2.Рамсарын конвенцид бүртгэлтэй ус намгархаг газрын хамгаалалт, менежментийг сайжруулах нэгдсэн тайланг шинэчлэн гаргах. | 55,0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргачлалын зөвлөмж өгч, гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна. | <p>Рамсарын конвенцийн тайланг шинэчлэх, цахимжуулах ажлыг БОУАӨЯ-ны Байгалийн нөөцийн бодлого хэрэгжилтийн газартай хамтран Рамсарын конвенцийн тайланг шинэчлэх, цахимжуулах ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын нэгдэн орсон Рамсарын конвенцид бүртгэлтэй ус намгархаг газрын хамгаалалт, менежментийг сайжруулах нэгдсэн тайланг шинэчлэн гаргах аж ахуйн нэгж байгууллагыг сонгон шалгаруулж, Баруун бүсийн тайлан боловсруулах ажлыг "Монголын шувуу судлалын нийгэмлэг" ТББ 2024.11.01-ний өдрийн 2024/30 дугаарт гэрээ,</p> <p>Төвийн бүсийн тайлан боловсруулах ажлыг "Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухааны сургууль" 2024.11.01-ний өдрийн 2024/29 дугаарт гэрээ, Зүүн бүсийн тайлан боловсруулах ажлыг "Зэрлэг амьтан судлах, хамгаалах төв" ТББ 2024.11.01-ний өдрийн 2024/31 дугаарт гэрээг тус, тус байгуулан ажиллаж байна.</p> | 90 |

| | | | | | | | | |
|----|--|--|---------------------------------|--------------------------------------|-----------------------------------|--|---|----|
| 10 | Арга хэмжээ 3.3.Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүс, тэжээгдлийн мужийг тогтоох, дэглэм мөрдүүлэх, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулахад СГЗ-дад дэмжлэг үзүүлэх. | | Орон нутгийн төсөв, бусад төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Сав газрын захиргаадад 5-аас доошгүй мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн зураглал хийж, Газрын нэгдсэн санд оруулсан байна. | Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүс тогтоох чиглэлээр СГЗ-дад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Дээрх ажлын хүрээнд Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн зураглал хийсэн ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, ээлжит цахим хурлуудыг зохион байгуулсан. "Ажлын хэсэг байгуулах тухай" Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1260 дугаар захирамжаар "Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай" Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 50 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах, Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолт болон хязгаарлалтын бүсийн хилд өөрчлөлт оруулах, цашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажилласан. Усны газраас Улаанбаатар хотын Био комбинат, Шувуун фабрик, Дээд эх үүсвэр, Багануур, Багахангай дүүргийн ус хангамжийн эх үүсвэрүүдийн эрүүл ахуйн хориглолт, хязгаарлалтын бүсийг тогтоох санал боловсруулсан. Мөн Туул голын сав газрын захиргаа, Нийслэлийн Байгаль орчны газарт хамтран Нийслэлийн усны сан бүхий газруудын хамгаалалтын бүсийг зурагласан бөгөөд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн "Нийслэл хотын усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай" 69 дүгээр тогтоолоор батлуулсан. Монгол улсын хэмжээнд "Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн хилийн заагийг газрын нэгдсэн системд оруулахад улсын хэмжээний дата өгөгдлийг бэлтгэх" ажлыг Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран хийж Газар зохион байгуулалт, Геодези зураг зүйн ерөнхий газрын LM системд оруулах бэлтгэл ажил хангагдаад байна. | 90 |
|----|--|--|---------------------------------|--------------------------------------|-----------------------------------|--|---|----|

Зорилт 4: Улсын усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээний байнгын тасралтгүй ажиллагааг хангаж, усны нөөц, горим, чанарын өөрчлөлтөд хяналт тавих, үнэлгээ өгөх, зохистой менежмент явуулах

| | | | | | | | | |
|----|--|-------|-----------------|--|-----|---|---|-----|
| 11 | Арга хэмжээ 4.1.Газрын доорх усны хяналт шинжилгээний цооног өрөмдөж, мониторингийн тоног төхөөрөмж суурилуулан газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбох, сайжруулах. | | Улсын төсөв | Шинээр өрөмдөж сүлжээнд холбосон цооногийн тоо | 6 | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн зөвлөмж өгч, Улсын усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээнд шинээр 4 цооногийг холбож, www.groundwater.mn портал хэвийн ажиллагааг хангасан байна. 200-аас доошгүй мониторингийн цооногийн засварласан байна. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Усны газрын даргын 2024 оны А/44 дугаар тушаалаар байгуулсан. Төндэрийн баримт бичгийг УГ-ын даргаар 2024.04.05-нд батлуулсан. 2024 оны 06 дугаар 05-ны өдөр гүйцэтгэгчийг шалгаруулах үнэлгээний хорооны хурлыг хийсэн бөгөөд "КТИМ" ХХК шалгарсан. Тус ажлын хүрээнд Газрын доорх усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээний гэмтэлтэй 126 цэгийн багаж тоног, төхөөрөмжийг улсын хэмжээнд засварлан, шинэчлэж, цооногийн хэвийн ажиллагааг ханган Усны газарт тайланг хэлэлцүүлэн хүлээн авсан. Өмнөговь аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 45 цэгийг засварлан багаж тоног төхөөрөмж суурилуулж нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулсан. Хувийн хэвшлийн санхүүжилтээр газрын доорх усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг 5 цэгээр өргөжүүлсэн. Үүнд:Өвөрхангай аймгийн байгаль орчны газар – 1 цэг /бүрэн автомат багаж/ Зэс эрдэнийн хувь ХХК – 2 цэг /бүрэн автомат багаж/ Эрдэнэс алт ХХК - 2 цэг /хагас автомат багаж/ | 100 |
| 12 | Арга хэмжээ 4.2.Галба-Өөш-Долоодын говь, Туул голын сав газрын хяналт-шинжилгээний цэгүүдийг сэргээн засварлаж, Улсын усны хяналт-шинжилгээний сүлжээнд холбох. | 500.0 | Төсөл, хөтөлбөр | засварласан мониторингийн цооногийн тоо | 325 | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, 120-иос доошгүй цэгийг сэргээн засварлаж, нэгдсэн сүлжээнд холбосон байна. | Улсын усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, тасралтгүй үйл ажиллагааг хангаж зорилтын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Галба-Өөш-Долоодын говийн сав газарт харьяалагдах 17 цэгийг тус сав газарт үйл ажиллагаа явуулж байгаа "Оюу толгой" ХХК-ийн дэмжлэгтэйгээр засвар хийж багаж, тоног төхөөрөмжийг суурилуулан нэгдсэн сүлжээнд холбоход бэлэн болсон; 2. Туул голын сав газрын захиргааны харьяанд байгаа хяналт-шинжилгээний 83 цэгийг сэргээн засварлах ажлыг Монголын мянганы сорилтын сангийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан. | 90 |

Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилт 3. Усны нөөцийн хомслоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцлийг бүрдүүлнэ.

Зорилт 5: Усны нөөцийг хомсдохоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцлийг бүрдүүлэх, голын тогдирлыг өөрчлөх, урсцад тохируулах хийж

| | | | | | | | | |
|----|--|----------|--------------------------------------|---|-----------------------------|--|---|-----|
| 13 | Арга хэмжээ 5.1.Увс аймгийн Өндөрхангай сумын Чигжийн голын хөв цөөрөмийн ажлын зураг төсөв боловсруулах | 50.0 | Усны нөөц, нуур гол мөрний менежмент | батлагдсан зураг төсөв | - | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргагүйн зөвлөмж өгч, гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна. | Увс аймгийн Өндөрхангай сумын Чигжийн голын хөв цөөрөмийн ажлын зураг төсөв боловсруулах ажил гүйцэтгэх эрхийг Увс нуур, Тэс голын сав газарт шилжүүлсэн. СГЗ-аас ажлын даалгаврыг боловсруулж, Увс аймгийн ЗДТГ-ын худалдан авах ажиллагааны газраас уг тендерийг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. | 90 |
| 14 | Арга хэмжээ 5.2.Хэрлэн гол дээр усан сан байгуулах, шилжүүлэн ашиглах техник эдийн засгийн үндэслэл боловсруулах | 11,000.0 | Хувийн хэвшлийн хөрөнгө | батлагдсан техник эдийн засгийн үндэслэл | 2014 онд боловсруулсан ТЭЗҮ | Техник эдийн засгийн үнэлгээний тодотгол хийгдэж, батлагдсан байна. | "Хэрлэн-тооно" төслийн ТЭЗҮ-ийн судалгааг шинэчлэх, тодотгол хийх Ажлын даалгаврыг хүргүүлсэн. 2024.06.19-ний өдрийн А/20 дугаар Эрдэнэс "Оюу Толгой" ХК-ийн гүйцэтгэх захирлын тушаалаар үнэлгээний хороо байгуулагдан ажилласан. Хэрлэн-Тооно ТЭЗҮ тодотгол хийх тендерийг 2024.07.02-нд зарлаж, 2024.08.20-нд нээсэн. Уг тендерт 3 компани материалаа ирүүлсэн бөгөөд 2024.08.26-нд тендерийн үнэлгээний хороо журагдаж хамгийн сайн тендер ирүүлсэн компаниар" Монхидроконстракшн" ХХК шалгарсан. Уг ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. | 100 |
| 15 | Арга хэмжээ 5.3.Хөв цөөрөм барих ажлын нэг мянгийн зураг төсөв боловсруулах, усны хуримтлалыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх | 300.0 | Улсын төсөв | батлагдсан зураг төсөв | - | Зураг төсвийг батлуулж орон нутагт хүргүүлж ажилласан байна. | Гуу жалга түшиглэн хөв цөөрөм байгуулах боомтын хөндлөн огтолын нэг загварын зураг төсөл боловсруулах ажлыг "Гидро сооружение" ХХК-ийг гэрээ байгуулан ажиллаж, одоогоор 6 төрлийн хөв цөөрөмийн байгуулах нэг мянгийн зургийн төслийг боловсруулан олон нийт, оролцогч байгууллагуудаас санал авах ажил хийгдэж байна. | 90 |
| 16 | Арга хэмжээ 5.4.Хөв цөөрөм, усан сан, усны хуримтлалыг бий болгох, газрын таарцын судалгааг хийх | 210.0 | Улсын төсөв | хөв цөөрөм, усан сан байгуулах газрын тоо | 2015 оны суурь судалгаа | Таарцын судалгааг хийж, хөв цөөрөм байгуулах боломжит цэгийн тоо, байршлыг тогтоосон байна. | Хөв цөөрөм, усан сан, усны хуримтлалыг бий болгох, газрын таарцын судалгааг хийхтэй холбоотойгоор 2024 онд хөв цөөрөмийн тохиромжтой байршлын судалгааг 12.5 метрийн өндрийн нарийвчлалтай орон зайн мэдээг ALOS PASLAR хиймэл дагуулын мэдээгээ татан авч боловсруулж тоон загварт үндэслэн усны эх үүсвэр, газрын хэвгийг, ус тогтоон хуримтлагдах боломжит газруудын байршлыг судлан 54016 цэгийг тодорхойлсон. Дээрх мэдээлэлд үндэслэн сав газар тус бүрийн нийгмийн хэрэгцээ шаардлага, хөв цөөрөм, усан сангийн зориулалт болон байгаль цаг уурын нөхцөл, газрын гадаргын онцлогтой уялдуулан 318 боломжит байршлыг сонгож, холбогдох саналыг боловсруулан ирүүлсэн бөгөөд уг мэдээллийг "Монгол орны хөв цөөрөмийн байршлын катологи"-ийг боловсруулан БОУАӨ сайдад танилцуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| 17 | Арга хэмжээ 5.5.Ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүдийг санхүүжилтээр уул уурхайн дүйцүүлэх нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд ус хуримтлуулах усан сан, хөв цөөрөм байгуулах | - | Хувийн хэвшлийн хөрөнгө | Шинээр байгуулах хөв цөөрөм, усан сангийн тоо | - | 2024 оны ус ашиглалтын тайланд тусгасан байна. Шинээр байгуулсан жижиг цөөрөм, усан сангийн тоог нийт 5-аар нэмэгдүүлсэн байна. | Увс аймгийн Хяргас сумын "Хорикава Металл" ХХК-д Нэг сум нэг нуур хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж, усны нөөцийг бохирдож, хомсгохоос хамгаалан ажиллах зөвлөмжийг Усны газраас хүргүүлсний дагуу "Ичээтийн гол" хөвийн зургийг уг компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд "Гидро-Фонтан" ХХК-аар хийлгэж, хөв байгуулахаар шийдвэрлэн ажиллаж байна. "Эрдэнэс таван толгой" ХК-ийн нүүрсний уурхайг гадаргын уснаас хамгаалах, түүнийг хуримтлуулах 3 хөв цөөрөм байгуулсан | 90 |
| 18 | Арга хэмжээ 5.6.Ил уурхайн аргаар ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгжүүдийн уурхайн карьер дахь шүүрлийн усны илүүдлийг хуримтлуулах замаар цөөрөм, усан байгуулах | - | Хувийн хэвшлийн хөрөнгө | Шинээр байгуулах хөв цөөрөм, усан сангийн тоо | - | 2024 оны ус ашиглалтын тайланд тусгасан байна. Шинээр байгуулсан жижиг цөөрөм, усан сангийн тоог нийт 10-аар нэмэгдүүлсэн байна. | Уул уурхайн компаниудад усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглох, голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглох, тусгай зөвшөөрлийн талбайн байгаа голыг хамгаалах арга хэмжээ авах, хөв цөөрөм байгуулах, татмын ойжуулалт хийх талаар шаардлага хүргүүлж, энэ ажлын хүрээнд "Багануур" ХК нь 3 нуурыг хамгаалж, 2 нуур шинээр байгуулах, "Галт үнэг" ХХК нь Өвөрхангай аймгийн Таралт суманд усалтын системийн зориулалтаар баригдсан усан санг сэргээн засварлахаар ажиллаж байна. Томоохон ус ашиглагчид буюу хоногт 100 шоометрэс их ус ашиглагч 50 гаруй уурхайнуудад уурхайн ухашаас шүүрэн орж ирэх шүүрлийн усыг эргүүлэн ашиглах, хуримтлуулах замаар цөөрөм, усан сан байгуулах талаар ус ашиглуулах дүгнэлтийн онцгой нөхцөлд даалгаж ажилласан. | 90 |

| | | | | | | | | |
|----|--|---------|-------------|----------------------------------|---|--|---|-----|
| 19 | Арга хэмжээ 5.7.Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх | 1,500.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргагүйн зөвлөмж өгч, гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна. | Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах ажлын II үе шатны ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж 2024.03.12-ны өдөр Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж гишүүдийн саналыг техникийн тодорхойлолт оруулан батлуулсан. Усны газрын даргын 2024.04.04-ны өдрийн А/45 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулж Төндөр шалгаруулалтын баримт бичгийг 2024.05.02-ний өдөр батлуулсан. БОАЖЯ/202401009/01/02 дугаар бүхий тендерийг 2024.05.28-ны өдөр нээхэд Багц 2 ажилд "Престиж Инженеринг" ХХК, Багц 4 ажилд "СДММ" ХХК шалгарч 2024.06.24-ний өдөр гэрээ байгуулсан. Тус тендерийн Багц 1 болон Багц 3 дахь ажлыг дахин зарлан 2024.07.09-ний өдөр нээхэд Багц 1 ажилд "Престиж Инженеринг" ХХК, Багц 3 ажилд "УБТ Гарден" ХХК шалгарч 2024.08.19-ний өдөр гэрээ байгуулан ажиллаж байна. 2024 оны 10 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд Ерөнхийлөгчийн тамгын газар, Усны газар, Дарьганга байгалийн цогцолборт газар, Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны бүрэлдэхүүн газар дээр нь ажиллаж мэргэжил аргагүйн зөвлөмж өгч ажилласан. Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах ажлын II үе шатны ажлын гүйцэтгэлд Усны газарт 3-5 удаагийн уулзалт зохион байгуулж, нарийвчилсан төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. Тус ажлууд нь 2025 онд ургэлжлэн хийгдэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд календарчилсан хуваарийн дагуу 2024 оны ажлыг гүйцэтгэн урьдчилсан тайланг ирүүлсэн байгаа. | 90 |
| 20 | Арга хэмжээ 5.8.Хэрлэн голын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх. | 900.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргагүйн зөвлөмж өгч, гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна. | Хэрлэн голыг бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2024.05.03-ны өдөр зарлаж, 2024.05.27-ны өдөр нээсэн. Тендерийн нээлтийг хийж, үнэлгээний хороо хурал зохион байгуулахад багц-1 болон багц-3 дээр санал ирээгүй. Багц 2 дээр 1 байгууллагаас санал ирүүлсэн нь тэнцээгүй. Захиалагчаар техникийн тодорхойлолтыг дахин батлуулж тендерийг 2 дахь удаагаа 2024.07.24-ний өдөр зарлаж, 2024.08.19-ны 10:30 цагт нээсэн. Тендерийг нээхэд 3 багц ажилд нэг ч байгууллага санал ирүүлээгүй, амжилтгүй тендер болсон. Үнэлгээний хороо хуралдаж ТББ-н шаардлага бууруулж дахин 3 дахь удаагаа 2024.08.23-ны өдөр зарлаж, 2024.09.18-ны 10:30 цагт нээсэн. Тендерт оролцох санал, материал ирүүлээгүй. Захиалагчаар техникийн тодорхойлолтыг дахин батлуулж, тендерийг 4 дэх удаагаа 2024.10.16-ны өдөр зарлаж, 2024.11.06-ны өдөр нээсэн. Тендерт оролцох санал, материал ирээгүй. | 70 |
| 21 | Арга хэмжээ 5.9.Булган аймгийн Баяннуур сумын Баян нуурыг сэргээх төслийг хэрэгжүүлэх | 560.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргагүйн зөвлөмж өгч, гүйцэтгэлийн тайланг хүлээн авч, нуурт ус хүрсэн байна. | "Булган аймгийн Баяннуур сумын Баян нуурыг сэргээх төслийг хэрэгжүүлэх" ажлын тендерийг 2024.04.08-нд зарлаж, 2024.04.30-нд нээсэн. Уг тендерт "Усны барилга" ХХК шалгарч, 2024.05.13-нд мэдэгдэл хүргүүлэн 2024.05.20-нд 556,375,000.0 төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. | 100 |
| 22 | Арга хэмжээ 5.10. Мөстлийн хайлалтын цас, мөсний усыг хуримтлуулах боломжийн судалгаа хийх | 95.0 | Улсын төсөв | судалганы тайлан | - | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргагүйн зөвлөмж өгч, гүйцэтгэлийн тайланг хүлээн авч, мөстлийн хайлалтыг хуримтлуулах байршил тодорхойлогдсон байна. | Мөстлийн хайлалтын цас, мөсний усыг хуримтлуулах боломжийн судалгаа хийж тайлан, зураг төсөл, загварыг бэлэн болгох техникийн тодорхойлолтыг боловсруулж, Усны газрын даргын 2024.03.06-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулсан. УГ/20240203011 дугаар бүхий тендерийг 2024.04.09-ний өдөр зарлан 2024.05.03-ны өдөр нээсэн боловч оролцогч аж ахуй нэгж материалаа ирүүлээгүй байсан. 2024.05.03-ны өдөр тендерийг дахин зарлан 2024.05.29-ний өдөр нээхэд 2 байгууллага материалаа ирүүлсэн боловч материалын бүрдлийг хангаагүйн улмаас тендер амжилгүй болсон. 2024.05.18-ний өдөр тендерийг дахин зарлаж "Ийрт плас" ХХК шалгарч 2024.08.19-ний өдөр УГ/20240203011/03/01 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Мөстлийн хайлалтын цас, мөсний усыг хуримтлуулах боломжийн судалганы ажлын явцын тайланг календарчилсан төлөвлөгөөний дагуу манай газарт ирүүлж эхний санхүүжилтийг олгосон. Эцсийн тайланг Усны газарт 2024.12.06-ний өдөр хэлэлцүүлэхээр төлөвлөж байна. | 90 |

| | | | | | | | | |
|--|--|-------|---------------------------------|-----------------------------------|--|---|--|-----|
| 23 | Арга хэмжээ 5.11.Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах | | Орон нутгийн төсөв, бусад төсөв | булаг шандын тоо | | Улсын хэмжээнд 100-аас доошгүй булаг шанд хамгаалсан байна. | Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас Монгол орны усны нөөцийг бохирдох, хомстохоос хамгаалах зорилтын хүрээнд булаг, шандын эхийг хамгаалах "100, 1000, 10000" төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд "Булгийн эхийг хамгаалах аргачлал" боловсруулж батлуулах ажлыг 2024 онд хамтран гүйцэтгэхээр төлөвлөсөн. Тайланг хугацаанд аргачлал боловсруулах ажлыг гүйцэтгэх зөвлөхийг сонгон шалгаруулж, ажлын даалгаврыг боловсруулсан. Ажил гүйцэтгэх гэрээг 2024.06.15-нд байгуулсан бөгөөд "Булгийн эхийг хашиж хамгаалах нэгдсэн аргачлал"-ыг Усны газрын даргын тушаалаар баталгаажуулах тушаалын төслийг боловсруулаад байна. Усны нөөцийг бохирдох, хомстохоос сэргийлэх зорилгоор булаг шанд, рашааны эхийг хашиж, хамгаалах ажлыг улсын болон орон нутаг, төсөв хөтөлбөр, хувийн хэвшлийн хөрөнгөөр хийж гүйцэтгэх тухай сав газрын захиргаадад чиглэл өгч ажилласан. Улсын хэмжээнд нийт 137 булаг шандын эхийг хашиж хамгаалсан. Үүнд: Төв-3, Дундговь-3, Сэлэнгэ-3, Дархан уул-2, Говь-Алтай-26, Өвөрхангай-24, Архангай-5, Хөвсгөл-9, Улаанбаатар-3, Баян-Өлгий-2, Увс-3, Булган-3, Говьсүмбэр-1, Дорноговь-18, Орхон-5, Өмнөговь-3, Ховд-10 Булгийн эхийн хашаа хайсны засвар үйлчилгээг 4 газарт хэрэгжүүлсэн. | 100 |
| 24 | Арга хэмжээ 5.12."Говь-Алтай аймгийн Жаргалан сумын нутагт орших Эрээн нуурыг сэргээх" ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах. | 841.3 | Бусад төсөв | Тендер сонгон шалгаруулсан байдал | Батлагдсан зурга төсөвтэй | Ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулна. | "Эрээн нуурыг сэргээх" ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2024.05.14-ний өдөр www.tender.gov.mn цахим хаягт байршуулан, 2024.05.29-ний өдөр тендерийг нээж Усны газрын даргын 2024.04.03-ны өдрийн А/41 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо холбогдох хууль, журмын дагуу ирүүлсэн материалыг хянан үзээд, ТББ-ын шаардлага хангасан тул "Усны эрчим" ХХК-тай 814,924,031.0 төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Уг ажлыг гүйцэтгэлд захиалагч болон зохиогчийн хяналтыг тухай бүр хийж, 1,2-р шатны тайланг хүлээн авч, 2024.11.20-ны өдрийн байдлаар гэрээт ажил 75%-ийн гүйцэтгэлтэй байна. Урсац тохируулах халиаг барилгын ажлыг дулааны улиралд хийж, туршилт тохируулгыг хийхээр ажил гүйцэтгэх гэрээг сунгав. | 90 |
| 25 | Арга хэмжээ 5.13."Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт Орхон-Тээгийн бэлчирт усан толио байгуулах" зураг төсөл боловсруулах ажил | 300.0 | Улсын төсөв | Тендер сонгон шалгаруулсан байдал | | Тендерийн бичиг баримтыг боловсруулж, гүйцэтгэчийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж, эхпертизээр батлагдсан зураг төсвийг хүлээн авна. | "Булган аймгийн Хишиг-Өндөр сумын нутагт Орхон-Тээгийн бэлчирт усан толио байгуулах" зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг 2024.06.26-ны өдөр www.tender.gov.mn цахим хаягт байршуулж, тендерийг 2024.07.25-ны өдөр нээж, Усны газрын даргын А/103 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо холбогдох хууль, журам, ТББ-ын дагуу ирүүлсэн материалыг хянан үзээд, хамгийн сайн тендер ирүүлсэн "Хидро-Инженеринг" ХХК-тай 264,000,000.0 төгрөгийн төсөвт өртөг бүхий ажил гүйцэтгэх гэрээг 2024.08.15-ны өдөр байгуулсан. | 100 |
| Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилт 4. Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрөл олгох үйл явцаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ. | | | | | | | | |
| Зорилт 6: Усны бохирдлыг бууруулах, цэвэрлэсэн болон саарал усны дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх. | | | | | | | | |
| 26 | Арга хэмжээ 6.1. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжаас доош Туул голын голдрол дагуу голын ёроолын хурдсыг цэвэрлэх | 120.0 | Төсөл, хөтөлбөр | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Техөөрөмжийг ажиллуулахад шаардагдах 5 техник хэрэгсэл, дагалдах багаж, төхөөрөмжөөс 4-ийг худалдан авсан. | Туул голын ёроолын хурдсыг цэвэрлэх төхөөрөмжийг ажиллуулан цэвэрлэсэн байна. | БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 03/3759 тоот албан бичгийн дагуу Усны газрын даргын 2024 оны А/123 тушаалаар "Гол, нуурын ёроолын хурдас, лаг цэвэрлэх тоног төхөөрөмжийг ажиллагаанд оруулах, ажил эрчимжүүлэх зорилгоор ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилж, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр болох Сонгины гүүрийн баруун талд Инженер геологи нөмт ХХК болон ХБНГУ-ын Schauenburg MAB компанийн 2 инженер, БНХАУ-ын 1 инженертэй хамтарч 2024.10.14-18 өдрүүдэд Catfish тоног төхөөрөмжийг туршилтаар амжилттай ажиллуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|----|---|---------|-----------------|----------------------------------|--|--|---|-----|
| 27 | Арга хэмжээ 6.2 Хөвсгөл нуурын бохирдлын судалгааг хийх | 150.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Тээврийн хэрэгсэл-1, усан онгоц-1, чиргүүл-1, автомашины ёмкость-1 татаж гаргасан. | Ажлын явцад гүйцэтгэлийг мэргэжил арга зүйгээр хангаж, хяналт тавьж, судалгааны тайлан, дүгнэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагуудтай хамтран эрсдэлийг арилгах төлөвлөгөө батлуулсан байна. | Усны газрын даргын 2024 оны А/23 дугаар тушаалаар үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичиг, ажлын даалгаврын төслийг боловсруулан үнэлгээний хороогоор хэлэлцүүлэн, захиалагчаар батлуулж, 2024.04.09, 2024.05.01, 2024.06.19-ний өдөр тус тус зарласан. Эхний 2 удаагийн тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул 3 дахь удаа зарлаж, тендерт оролцох хүсэлт ирүүлсэн Баруунхуасай ХХК, Газарзүй геоэкологийн хүрээлэнгийн туншлал, Инженер геолог номт ХХК, Ийрт палас ХХК, Найчрал Састайнэблз ХХК-ийн материалыг хүлээн авч, үнэлгээний хороогоор хэлэлцүүлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11.4 дэх хэсэгт заасны дагуу шавардлагад нийцсэн тендерүүдийг "харьцуулах үнэ"-ийн аргаар дүгнэж, Найчрал Састайнэблз ХХК-ийг хамгийн сайн тендерийн санал ирүүлсэн гэж үнэлэн, захиалагчид зөвлөмж хүргүүлсэн. Захиалагч буюу, Усны газар 2024.08.12-ны өдөр Найчрал Састайнэблз ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу эхний тайланг 2024.09.05, сүүлийн тайланг 2024.10.25-ны өдөр тус тус хүлээн авч, 2024.11.08-ны өдөр Усны газрын холбогдох албан хаагчаар хэлэлцүүлэн, ажлын даалгаварт заасны дагуу хянан, засварыг хийлгэж, тайланг эцсийн байдлаар хүлээн авсан. | 100 |
| 28 | Арга хэмжээ 6.3 Өгий нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах 2 дугаар үе шатны ажлыг хэрэгжүүлэх | 1,500.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 1 дүгээр үе шат хэрэгжсэн. | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргазүйн зөвлөмж өгч, гүйцэтгэлийн тайланг хүлээн авсан байна. | Усны газрын даргын 2024 оны А/03 тушаалаар ажлын хэсэг байгуулж, Өгий нуурт хийгдсэн ажлыг хэлэлцэн, ажлын даалгаврыг тодорхойлж, Усны нөөцийн зөвлөлийн хуралд танилцуулан, 5 гишүүнээс ирүүлсэн саналыг тусгах, Ерөнхийлөгчийн Байгаль орчны зөвлөхөөс санал авч, Усны газрын даргын 2024 оны А/57 тушаалаар байгуулсан үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг хэлэлцэн, захиалагчаар батлуулж, 2024.05.03, 2024.06.27-нд тус тус зарласан. Багц-1, багц-4 ажлыг Инженер геолог номт ХХК, багц-2 ажлыг Цастхайрхан констрашн ХХК-ийг шалгаруулж, багц-3 ажлыг Онцгой байдлын албаар гүйцэтгүүлэх зөвлөмжийг захиалагчид хүргүүлж, 2024.08.12-нд багц-1, 2, 4 ажлын гэрээг байгуулан 2024 оны эцсийн тайланг 2024.11.25-нд тус тус хүлээн авч, 2024.11.08-нд Усны газраар, 2024.12.06-нд БОУАӨЯ-аар хэлэлцүүлж, ТБОНӨХБАУХА тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтыг зохион байгуулан, холбогдох бичиг баримтыг Сангийн яамны https://pimis.publicinvestment.gov.mn/ цахим системд оруулж, 2024 онд ногдох санхүүжилтийг олгуулахаар ажиллаж байна. Багц-1 ажлын хүрээнд хөгшин Орхон гол дээр гидрологийн хэмжилт, судалгаа, Өгий нуурын усны балансын судалгаа, Хархорин усалгааны сувагт 17 км газарт геодезийн хэмжилт судалгаа тус тус хийгдсэн. Хархорин усалгааны сувгийн гидротехникийн зургийг шинэчилэн зурсан, голын хөгшөөс цэвэрлэх тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаанд оруулж, туршсан, ажлын явц 50%-тай байна. Багц-2 ажлын хүрээнд нуурын баруун талын зэгс, шагшuurгыг хамгаалах 10 км хамгаалалтын хашаанаас 7 км хашаа, мэдээллийн 4 самбараас 1 самбар, Хойд Мэргэн шанаанаас Урд Мэргэн шанаа хүртэл хийх 3.7 км хөвүүрээс туршилтаар 40 метр хөвүүрийг тус тус хийж гүйцэтгэсэн, ажлын явц 70%-тай байна. Багц-4 ажлын хүрээнд Өгий нуурын замгийн судалгаа, нуурыг бохирдуулахгүй, эко системийг доройтуулахгүй байхаар дахин төлөвлөлтийн зургууд хийж, төлөвлөгөөнд тулгуурласан менежментийн санал боловсруулсан, ажлын явц 95%-тай байна. | 90 |
| 29 | Арга хэмжээ-6.4.Усны нөөц, ус ашиглалт, хаягдал усны дүгнэлтүүдийг цахим дүгнэлт болгох ажлыг хэрэгжүүлэх, "Усны өгөгдлийн удирдлагын систем" хөгжүүлэх | - | Төсөл, хөтөлбөр | цахим болсон дүгнэлтийн тоо | - | Улсын хэмжээнд усны нөөц, ашиглалт, хаягдлын дүгнэлт цахим болсон байна. | Ус ашиглуулах дүгнэлтийг цахимжуулах ажлыг Аствишн ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна. Усны өгөгдлийн системийг хөгжүүлж усны нөөцийн дүгнэлт, ус ашиглалтын дүгнэлт, хаягдал усны дүгнэлт болон бохир усны чанарын мэдээллийг цахим болгох замаар төрийн үйлчилгээг ил тод нээлттэй, хурдан шуурхай болгохоор программ гүйцэтгэлч "Аствишн" ХХК-ийн ажлын байранд ус ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд ажилласан. 2024 оны 03 сарын 22-ны өдрөөс эхлэн ус ашиглуулах дүгнэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэж байна. 2024 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар ус ашиглуулах цахим дүгнэлт шийдвэрлэсэн 136, ус ашиглалтын хэлтсийн дэргаар хянуулж, нэхэмжлэл илгээсэн 4, боловруулж байгаа 3, засварт буцаасан 5 дүгнэлт байна. Системийг ашиглах явцад гарч байгаа хүндрэлүүдийг цаг тухай хөгжүүлэгч байгууллагад мэдэгдэн асуудлыг шийдвэрлүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|----|--|---|-------------------------|----------------------------------|---|--|--|----|
| 30 | Арга хэмжээ 6.5. Аж ахуйн нэгж байгууллагуудад усыг зохистой ашиглах, усны нөөцийг хэмнэх, тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх, усны алдагдлыг бууруулах, ус ашиглалтыг бодитоор тооцох нөхцөлийг бүрдүүлж тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх, тайлагнах хэрэгжилтэд хяналт тавих | - | Хувийн хэвшлийн хөрөнгө | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | тоолуур суурилуулсан аж ахуйн нэгжийн тоо 1655 байна. | Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийг тоолууржуулах, усны алдагдлыг багасгах чиглэлээр зөвлөмж хүргүүлж, хяналт тавих, холбогдох газруудаас тоолууржуулалтын мэдээллийг авч нэгтгэсэн байна. | Хоногт 100 шоометрээс их ус ашиглагч 265 аж ахуйн нэгж байгууллагад, усаар хангагч 19 байгууллагад усны нөөцийг зохистой ашиглах, тоолууржуулахыг даалгаж, биелэлтийг хангах талаар зөвлөмж, аргазүйгээр хангаж ажилласан. Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийн 80-иас багагүй хувь нь ус авах цэг, шугам хоолой бүрийг тоолууржуулсан. | 90 |
|----|--|---|-------------------------|----------------------------------|---|--|--|----|

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ

Усны тухай хуулийн 161- дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 28.4, 28.7, 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль

Зорилт 7: Усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих.

| | | | | | | | | |
|----|---|---|-------------|--|-----|---|--|-----|
| 31 | Арга хэмжээ 7.1. Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргах | - | - | Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн тоо | 233 | Ус боломжит нөөцийн дүгнэлтийг 120-оос доошгүй байгууллагад хугацаанд нь гаргаж мэдээ тайланг нэгтгэсэн байна. | Усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаар хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байгууллагуудын материалын судлан үзэж албан бичгээр 145, цахимаар 155 нийт 300 аж ахуйн нэгж байгууллагад дүгнэлт гарган хүргүүлсэн. БОУАӨЯ-ны Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлалын мэргэжлийн зөвлөлийн хуралд тухай бүр оролцож явсан. | 100 |
| 32 | Арга хэмжээ 7.2. Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулсан, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын ус ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх | - | Улсын төсөв | Хяналт-шалгалтын тоо | - | Аж ахуйн нэгж байгууллагуудад усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилт ус ашиглалтын байдалд 4-өөс доошгүй удаагийн хяналт, шалгалт хийж, эерчил дутагдлыг ариллуулах арга хэмжээ авсан байна. | Усны газрын даргын 2024 оны А/58 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Хэнтий, Дорнод аймагт 2024 оны 04-р сарын 11-16-ны өдрүүдэд ажилласан бөгөөд Дорнод аймгийн Цагаан-Овоо, Хэрлэн, Халхгол, Матад сум, Хэнтий аймгийн Хэрлэн суманд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй "Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК, "Дорнод НАА" ОНӨААТҮГ, "Петрочайна дачин тамсаг" ХХК, "Хэнтий ус" ХХК, "Степ голд" ХХК-ийн учд ахуй болон технологийн ус ашиглалт, хаягдал усыг эргүүлэн ашиглаж буй үйл ажиллагаа, "Дорнод НАА" ОНӨААТҮГ, "Хэнтий ус" ХХК-ийн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаатай танилцаж, шаардлагатай цэгүүдээс хаягдал усны хяналтын сорьцын дээж авч, Дорнод, Хэнтий аймагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй томоохон ус ашиглагч байгууллагууд, байгаль орчны байцаагч, татварын албаны байцаагч нарт хаягдал усны дүгнэлт гаргах, ус бохирдуулсны төлбөрийг эрхэн ногдуулах талаар сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших "Эрдэнэс алт ресурс" ХХК-ийн ус ашиглалтын байдалд хяналт шалгалт хийхээр 2024 оны 05 сарын 16-17-ны өдрүүдэд томилолтоор ажилласан. Нийслэлийн Багануур дүүргийн нутагт ган төмөрлөгийн үйл ажиллагаа явуулдаг "Дөл түшиг" ХХК-ийн ус ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж 2024.10.25-ны өдөр ажилласан. Усны газрын даргын 2024 оны А/80 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 05 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй "Эрээн толгой" ХХК-ийн нүүрсний уурхайн үйл ажиллагаатай танилцаж, ус ашиглалтын байдал болон Усны тухай хууль болон Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж буй эсэхэд хяналт тавьж ажилласан. | 100 |

| | | | | | | | | |
|----|--|---|-------------|----------------------------------|---|--|---|-----|
| 33 | Арга хэмжээ 7.3.Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох | - | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | 8 | Аж ахуйн нэгжийн усны нөөцөд учирсан хохирлыг тооцох, нөхөн төлбөр тооцох, нөхөн төлбөрийг барагдуулах үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | Ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлгүй ажилласан аж. ахуйн нэгж байгууллагын судалгааг сав газрын захиргаагаас авч нэгтгэсэн. Усны нөөцөд учирсан хохирол нөхөн төлбөр тооцоулах 30 зөрчлийн хэрэгт шинжээчээр ажиллах, 19 зөрчлийн хэрэгт усны нөөцөд учирсан нийт 110,350,000 (Зуун арван сая гурван зуун тавин мянган) төгрөгийн хохирол тооцож аймаг нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлсэн байна. | 100 |
|----|--|---|-------------|----------------------------------|---|--|---|-----|

Зорилт 8: Усны тоо бүртгэл, статистик мэдээлэл, кадастрын мэдээллийг бүрдүүлж, улсын усны мэдээллийн санг өргөжүүлнэ.

| | | | | | | | | |
|----|--|-------|-------------|---|-----|---|---|-----|
| 34 | Арга хэмжээ 8.1. Улсын усны мэдээллийн санд е.с.мл-д сав газрын захиргаадын мэдээллийг төвлөрүүлэх | - | - | Улсын усны мэдээллийн сангийн мэдээллийг бүрдэлийн хувь | 100 | Улсын усны мэдээллийн сангийн мэдээлэл бүрдсэн байна. | Улсын усны мэдээллийн санд өмнөх оны мэдээллүүдийг хянаж, зөрүүтэй тоо мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулсан бөгөөд иргэн аж ахуй нэгж байгууллагуудыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| 35 | Арга хэмжээ 8.2.Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Байгаль орчны мэдээллийн санд БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу оруулсан мэдээллийг хяналт, мэргэжил аргагүйн зөвлөмж өгөх | - | - | БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дүн мэдээний хувь | 100 | БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу холбогдох мэдээллүүдийг хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд 100 хувь оруулсан байна. | Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу холбогдох мэдээллүүдийг хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд оруулсан. Монгол орны усны тоо бүртгэлийн 2023 оны дүн мэдээгээр: -Нуур, тойром – 4439; -Гол, мөрөн – 6841; -Булаг, шанд – 14357; -Рашаан – 639; -Усан сав, хөв цөөрөм – 304; -Худаг – 73768 тоологдсон. | 100 |
| 35 | Арга хэмжээ 8.3.Усны мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэлтийг хангаж, улсын усны төлөв байдлын тайланг гаргах | - | - | Усны төлөв байдлын тайлангийн хувь | 100 | Усны мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэлтийг хангаж, 2023 оны улсын усны төлөв байдлын тайланг гаргаж БОУАӨЯ-нд хүргүүлсэн байна. | Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/168 дугаар тушаалаар баталсан "Монгол орны байгаль орчны 2021-2023 оны төлөв байдлын тайлан боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Байгалийн нөөцийн бодлого зохицуулах газрын мэргэжилтэн Т.Давааням болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд цахимаар хүргүүлсэн. | 100 |
| 37 | Арга хэмжээ 8.4.Улсын усны мэдээллийн санг сайжруулах. | 150.0 | Улсын төсөв | Гүйцэтгэлийн хувь | - | Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил, аргагүйн зөвлөмж өгч, Байгаль орчны мэдээллийн төвийн www.eis.mn порталыг хөгжүүлэлт хийж, улсын усны мэдээллийн санг сайжруулсан байна. | Улсын усны мэдээллийн санг сайжруулах техникийн тодорхойлолтийг боловсруулж, Усны газрын даргын 2024.04.19-ний өдрийн А/66 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулсан. УГ/20240103016 дугаар бүхий тендерийг 2024.05.24-ний өдөр нээхэд 3 байгууллага материалаа ирүүлсэн боловч материаларийн бүрдлийг хангаагүйн улмаас тендер амжилгүй болсон. 2024.06.18-ны өдрийг тендерийг дахин зарлаж "Эрхэт Инноваци" ХХК шалгарч 2024.08.14-ний өдөр УГ/20240103016/02/01 дугаартай гэрээ байгуулан ажиллаж байна. Улсын усны мэдээллийн санг хөгжүүлэх www.infowater.gov.mn цахим платформ бүтээсэн бөгөөд зүлхрүүлэх, тохируулах ажил үргэлжилж байна. Төрийн болон ус ашиглагч байгууллагууд, судалгаа шинжилгээний байгууллагуудын дотоод усны мэдээллийн санг нэгтгэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн техникийн баримт бичиг боловсруулсан. Усны нөөц, ашиглалтын жилийн мэдээллийг боловсруулах аргачлал, гарын авлага боловсруулан 1000 ширхийг хэвлүүлсэн бөгөөд түгээх ажлыг зохион байгуулж байна. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны харьяа Байгаль орчны мэдээллийн төвийн Ой, ус тусгай хамгаалалттай газрын кадастрын лавлагааны мэдээллийн санг Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн ерөнхий газрын дундын мэдээллийн санд холбоход бэлэн болсон. Ажлын үр дүнг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Усны газарт танилцуулга хийж, эцсийн тайлан, техникийн баримт бичиг, гарын авлагыг хүлээлгэн өгсөн. | 100 |

Зорилт 9: Ус ашиглалтыг зохицуулах, хяналт тавих, ус ашиглалтын мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргах

| | | | | | | | | |
|--|---|---|-------------|---|--|--|--|-----|
| 38 | Арга хэмжээ 9.1.Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангалт байгууллагад ус ашиглуулах дүгнэлт гаргах | - | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 онд 33 байгууллагад дүгнэлт гаргасан | Цахим дүгнэлт гаргаж, дүгнэлт гаргах хугацаа богиноссон байна. | Ус ашиглалтын хэлтсээс усаар хангагч 19 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргасан. Усаар хангагч байгууллагуудаас ус ашиглуулах дүгнэлт гаргасан мэдээллийг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн. Ус ашиглуулах дүгнэлтээр урьдчилсан байдлаар төлбөр ногдуулсан усны хэмжээ 144.6 сая.м3/жил, усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 151.0 тэрбум төгрөг төвлөрөхөөр байна. | 100 |
| 39 | Арга хэмжээ 9.2.Хонгт 100 шооцмэтрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тазерийн зориулалтаар ус ашиглуулах дүгнэлт гаргах | - | - | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | 2023 онд 217 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргасан. | Цахим дүгнэлт гаргаж, дүгнэлт гаргах хугацаа богиносж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. | 2024 оны ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг сав газар, аймаг, нийслэлээр нэгтгэн гаргасан. 2024 оны 12 сарын 05-ны байдлаар 265 аж ахуй нэгж, байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, мэдээллийг савбараар, сав газрын захиргаа, аймаг, нийслэлээр нэгтгэн гаргасан. Урьдчилсан байдлаар төлбөр ногдуулсан усны хэмжээ 202.7.0 м3/жил, нийт төлбөрийн дүн 163.1 тэрбум төгрөг байна. Ус ашиглуулах дүгнэлт гаргуулсаны үйлчилгээний хөлсөнд 1.9 тэрбум төгрөгийг нэхэмжилэн Төрийн санд төвлөрүүлсэн. | 100 |
| 40 | Арга хэмжээ 9.3.Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавих | - | Улсын төсөв | Арга хэмжээний хэрэгжилтийн хувь | Сав газар, байгаль орчны газрын гаргасан ус ашиглуулах дүгнэлтэд хяналт тавьсан байна. | Сав газар, байгаль орчны газрын гаргасан ус ашиглуулах дүгнэлтэд хяналт тавьсан байна. | 29 Сав газрын нийт 177 ус ашиглуулах дүгнэлт, 205 гэрээ, 194 зөвшөөрлийн мэдээллийг авч нэгтгэн, хянасан. Урьдчилсан байдлаар 29 сав газрын ус ашигуулах дүгнэлтээр 3.6 сая.м3 ус ашиглуулахаар дүгнэлт боловсруулсан. Аймаг, нийслэлийн Байгаль орчны газруудын нийт 396 ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг нэгтгэн, хяналт тавьж ажилласан. 21 аймаг, нийслэлийн ус ашиглуулах дүгнэлтээр урьдчилсан байдлаар 1,5 сая.м3 ус ашиглуулахаар дүгнэлт гаргасан байна. 2024.09.05-ны өдрөөс 2024.09.11-ний өдрүүдэд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт ашигт малтмал олборлон баяжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. 2024.09.26-ны өдрөөс 28-ний өдрүүдэд Төв аймгийн Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сум, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумдын нутагт ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд Ус ашиглуулах 14 дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | 100 |
| 41 | Арга хэмжээ 9.4.Голын голдирлыг өөрчлөх, урсгад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах | - | - | Ирүүлсэн хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байдал | Усны барилга байгууламжийн зураг төсөлд 18 дүгнэлт гаргасан. | Усны барилга байгууламжийн зураг төсөл хийлгэхээр ирүүлсэн хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж дүгнэлт гаргаж, нэгдсэн танилцуулга бэлтгэсэн байна. | "ХЗТ-Авто зам" ХХК боловсруулсан Хэнтий аймгийн Чингис хотыг тойрон гарах 14.42 км авто зам болон Мөрөн сумын 3-р багийн нутагт Хэрлэн гол дээр хийгдэх 265.72 у/м төмөрбегон гүүр барих усны барилга байгууламжийн зураг төслийн дүгнэлт гарган хүргүүлсэн. "Монполимет" ХХК-ийн голын голдирол өөрчилсөн тухай дүгнэлт, "Блю глоб инержи" ХХК, "Гидродизайн инноваци" ХХК, "Их мянган инженерчлал" ХХК, "Эм ти эс гидро инженеринг" ХХК, "Дөргөн гүн" ХХК, "Гидро-Ус" ХХК-удын усны барилга байгууламжийн зураг төсөлд дүгнэлт гаргасан. | 100 |
| Зорилт 10: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих. | | | | | | | | |
| 42 | Арга хэмжээ 10.1.Хаягдал усны дүгнэлт гаргах | - | - | Хаягдал усны дүгнэлт гаргуулсан тоо | 2023 онд 174 хаягдал усны дүгнэлт гаргасан | Цахим дүгнэлт гаргаж, дүгнэлт гаргах хугацаа богиносж, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. | I сард 22, II сард 30, III сард 13, IV сард 36, V сард 5, VI сард 18, VII сард 4, VIII сард 7, IX сард 3, X сард 17, XI сард 5, XII сард 3, нийт 160 хаягдал усны дүгнэлт гаргасан. | 100 |
| 43 | Арга хэмжээ 10.2.Ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр тооцож, ногдуулах | - | - | Ногдуулсан төлбөр, нөхөн төлбөрийн дүн | 2023 онд 5.51 тэрбум төгрөгийн төлбөр, 638.4 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан. | Ус бохирдуулагчдын 2024 оны II, III улирлын төлбөр, нөхөн төлбөрийг тооцож, Татварын албанд хүргүүлсэн байна. | Жилийн эцсийн дүнгээр хаягдал усны 160 дүгнэлт, I, II, III улирлын 55 төлбөр тооцсон дүнгээр ус бохирдуулсны төлбөрт 10.3 тэрбум төгрөг, нөхөн төлбөрт 1.44 тэрбум төгрөг, нийт 11.74 тэрбум төгрөг ногдуулж, төлбөрийн мэдээллийг хамтран ажиллах гэрээнд заасан тайлан ирүүлэх маягтын дагуу сар бүр Татварын ерөнхий газарт цахимаар хүргүүлсэн. 2024.12.04-ний байдлаар 3812 ус бохирдуулагчаас 1.69 тэрбум төг Улсын төсөвт төвлөрсөн байна. | 100 |
| 44 | Арга хэмжээ 10.3.Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх, урамшууллын механизмыг хэрэгжүүлэх | - | - | Хөнгөлсөн, чөлөөлсөн төлбөрийн дүн | 2023 онд 236.8 сая төгрөгийг хөнгөлж, 4.6 тэрбум төгрөгийг чөлөөлсөн. | Ус бохирдуулагчдын 2024 оны II, III улирлын хөнгөлсөн, чөлөөлсөн төлбөрийг тооцож, Татварын албанд хүргүүлсэн байна. | Жилийн эцсийн дүнгээр 191.74 сая.м ³ эргүүлэн ашигласан хаягдал уснаас 9.13 тэрбум төгрөг, айл өрхөөс 202.68 сая.төгрөгийг тус тус чөлөөлж, төсөвт байгууллагуудаас 85.5 сая.төгрөг хөнгөлж, тухай бүр Татварын ерөнхий газарт цахимаар хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|--|--------------------|-----------------------------|---|---|---|---|-----|
| 45 | Арга хэмжээ 10.4.Ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагын хаягдал усны хэмжээ, чанарын төлөв байдалд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавих, хаягдал усны чанарын төлөв байдлын тайланг хүлээн авч, усны мэдээллийн санд оруулах | - | - | Ажлын явцад хяналт тавьсан байдал | - | Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчдийн хаягдал усны чанарын төлөв байдалд хяналт тавьж ажилласан байна. | Жилийн эцсийн дүнгээр аж ахуйн нэгж байгууллагуудын хаягдал усны дүгнэлт гаргуулах 163 хүсэлт, улирлын төлбөр тооцуулах 55 хүсэлтийг хүлээн авч, хаягдал усны хэмжээ, чанарын төлөв байдалд хяналт тавьж, мэдээллийг нэгтгэн, цаг тухай бүр байгууллагын вэбсайтад байршуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд тайлагнаж ажиллав. | 100 |
| 46 | Арга хэмжээ 10.5.Усны хяналтын төв лабораторийн үйл ажиллагааг хэвийн явуулах, лабораторид ирсэн усны хими, микробиологи, хүнд металлын, химийн шинжилгээний үр дүнг хянаж, мэдээлэх, мэргэжил арга зүй, удирдлагаар хангах | холбогдох зардлаар | Улсын төсөв | Шинжилгээний тоо | 2023 онд цэвэр усны 1141, бохир усны 494, хүнд металл 974, цэвэр усны нян судлал 416, бохир усны нян судлал 356, хөрсний 30 сорьцонд химийн шинжилгээ хийгдсэн. | Цэвэр усны хими 400, бохир усны хими 200, хүнд металл 200, цэвэр усны нян судлал 360, бохир усны нян судлалын 140 сорьцод шинжилгээг хийж гүйцэтгэнэ. | Нийт 3028 усны сорьцод 34506 үзүүлэлтээр шинжилгээ хийж, үр дүнг хянан, баталгаажуулсан. Үүнд: хаягдал усны химийн-389 сорьц, цэвэр усны химийн- 960 сорьц, цэвэр усны нян судлалын-836 сорьц, бохир усны нян судлалын- 214 сорьц, бичил элементийн -358 сорьцод шинжилгээ хийсэн байна. Шинжилгээний процесс, шинжилгээний үнэн бодит байдлыг шалгах аудит -1 удаа, багаж тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг шалгах, шалгалт тохируулгын ажлыг 1 удаа зохион байгуулж, СХЗГ-аар баталгаажуулсан. Лабораторийн ажилчдын үр чадварыг дээшлүүлэх MNS ISO/IEC 17025:2018 стандартын итгэмжлэлийн сургалтад 4 ажилтныг хамруулж, гэрчилгээ авсан. | 100 |
| 47 | Арга хэмжээ 10.6. Бохир усны шинжилгээний үзүүлэлтийг нэмж бохир усны цогц шинжилгээний төв болгох | 580,6 | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Шинжилгээний үзүүлэлтийн тоо | 28 үзүүлэлт | 37 үзүүлэлтээр шинжилгээг хийдэг болсон байна. | Усны газрын Усны хяналтын төв лабораторийг Хаягдал усны чанарын MNS6561:2024 стандартын 30 үзүүлэлт, MNS4943:2015 стандартын 44 үзүүлэлтийг бүрэн шинжлэх тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг Мянгань Сорилтын сан болон Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулж, 2025 оны 05 сард хүлээж авахаар тендер зарлагдсан байна. Бохир усны хүнд металлын сорьцын шинжилгээг хүнцэл, селен, уран, рубиди, анзан, биндер, теллур гэсэн үзүүлэлтээр нэмж тодорхойлдог болсон. Багаж, тоног төхөөрөмжийн тохиргоо калибровкийг хөндлөнгийн шинжилгээгээр баталгаажуулсан. | 100 |
| 48 | Арга хэмжээ 10.7. Лабораторийг олон улсын үр чадварын сорилтод хамруулж лабораторийн чамамжийг баталгаажуулах | 2.0 | Улсын төсөв, төсөл хөтөлбөр | Олон улсын үр чадварын хөтөлбөрийн үр дүн | Үндэсний болоод олон улсын үр чадварын сорилт зохион байгуулах эрх бүхий байгууллагын сорилд хамрагдсан байна. | Олон улсын үр чадварын сорилт хөтөлбөрт хамрагдсан байна. ANAB-CGL | Олон улсын үр чадварын хөтөлбөр зохион байгуулах эрх бүхий байгууллага болох Геологийн төв лабораториос 2024 оны 3 сард зохион байгуулсан Олон улсын үр чадварын "CGL PT03 WATER"SECOND ROUND сорилтын хөтөлбөрт цэвэр усны химийн нийт 15 үзүүлэлтээр химич Н.Халиунаа оролцож "Хангалттай сайн" гэрчилгээ авсан болно. Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораториос зохион байгуулсан Үндэсний үр чадварын хөтөлбөрт хими, нян судлалын шинжилгээгээр оролцож, 3 гэрчилгээ авсан. | 100 |
| ГУРАВДУГААР ХЭСЭГ: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ | | | | | | | | |
| Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний зорилт 5. Салбарыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүнд сурталгүй, хүртээмжтэй, ил тод, хялбар хүргэх | | | | | | | | |
| Зорилт 11.Усны салбарын хууль эрх зүйн орныг боловсронгуй болгох | | | | | | | | |
| 49 | Арга хэмжээ 11.1.Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж гарах, дүрэм, журам, стандартыг боловсруулах | 50.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Шинэчлэн боловсруулсан төслийг холбогдох талуудаар хэлэлцүүлэн, БОУАӨЯ болон хамтран шийдвэр гаргах бусад яамдад хүргүүлсэн байна. | Усны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах болон шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журам, стандартыг боловсруулах ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/47 дугаартай "Төсвийн зардлын хуваарь баталж, эрх шилжүүлэх тухай" тушаалаар 50.0 сая төгрөгийн эрх шилжүүлэн авч хууль, журмын төсөл боловсруулах үйлчилгээ бүхий худалдан авах ажиллагааны тендер зарлаж, Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж гарах дүрэм, журам, стандартыг боловсруулах ажлыг Байгаль экологи ХХК-тай 2024.08.07-ны өдөр гэрээ байгуулж санхүүжилтийг олгосон. | 90 |

| | | | | | | | | |
|--|---|-------|-----------------|--|-----------------------------------|--|---|-----|
| 50 | Арга хэмжээ 11.2 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах | 50.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Хуулийн төслийг холбогдох талуудаар хэлэлцүүлэн, БОУАӨЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлсэн байна. | Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулахаар БОАЖЯ-наас Сангийн яаманд 2024.02.26-ны өдрийн 01/897 тоот албан бичгээр хүргүүлж, батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2024.04.29-ний 01/2003 тоот албан бичгээр хүргүүлж батлуулсан. Үүний дагуу Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар 8 заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, 1 заалтыг нэмж батлуулсан. | 90 |
| 51 | Арга хэмжээ 11.3 "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г шинэчлэн тогтоох ажлыг зохион байгуулах | - | Төсөл, хөтөлбөр | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Шинэчлэн боловсруулсан төслийг холбогдох талуудаар хэлэлцүүлэн, БОУАӨ-ын Сайд, БХБ-ын Сайдад хүргүүлсэн байна. | Монголын Мянганы сорилтын сангийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны А-816/218 тоот хамтарсан тушаалаар баталсан "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ"-г Еврохан болон Seureca компанийн зөвлөхүүдээр "Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, Ерөнхий шаардлага MNS 6561:2024" стандартын төсөлтэй уялдуулан шинэчлэн боловсруулгаж, БОАЖЯ-наас 2024 оны 03/2762 тоотор УУХУЯам, БХБЯам, ХХААХУЯам, ХСУХАТАУЗХороо, Ус сувгийн удирдах газар ОНГААТҮГ-аас саналыг авч, эрх ашиг нь хөндөгдөх талуудаар хэлэлцүүлэг хийхээр ХББОСЯ-ны НААБЗГ-ын ахлах шинжээч г.Ганбаатартай хамтран ажиллаж байна. | 100 |
| 52 | Арга хэмжээ 11.4 Цооног битүүмжлэх аргачилсан заавар боловсруулах | 20.0 | Хувийн хэвшил | Цооног битүүмжлэх аргачилсан заавар | - | Аргачилсан заавар боловсруулж, Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн байна. | Газрын доорх усыг олон нийтэд таниулах, ач холбогдлыг нь сурталчлах "Гүнзгээ хайрлай" мэдээллийн аяныг "Оюу толгой" компани санаачлан Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Монголын Гидрогеологичдын холбоо, Галба-Өөш Долоодын Говийн сав газрын захиргаа, ШУТИС-ийн ГУУС-ийн Геологи, Гидрогеологийн салбар сургуультай хамтран гурав дахь жилдээ хэрэгжүүлж байгаа бөгөөд тус аяны 2024 оны төлөвлөгөөнд Цооног битүүмжлэх аргачилсан заавар боловсруулах аргачлал боловсруулах ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн. 2024.10.29-ний өдрийн 01/1092 тоот албан бичгээр "Оюу толгой" ХХК-д хамтран ажиллах хүсэлт хүргүүлсэн. Тус ажлын гүйцэтгэлийг сонгон шалгаруулах ажил үргэлжилж байгаа бөгөөд 2025 онд БОУАӨ-ийн сайдаар батлуулна. | 90 |
| Зорилт 12: Олон нийтийн хамтын ажиллагааг өргөжүүлж, усны тухай хууль, тогтоомжуудыг сурталчилах, салбарын гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэн хэрш орнуудтай байгуулсан "Хилийн усыг хамгаалах, ашиглах тухай" хэлэлцээрийг хэрэгжүүлэх | | | | | | | | |
| 53 | Арга хэмжээ 12.1 Хилийн усыг хамгаалах, ашиглах Засгийн газар хоорондын хэлэлцээр, Хилийн усны ажлын хэсэг, шинжээчдийн багийн уулзалтыг зохион байгуулах /ОХУ, БНХАУ/. | 120.0 | Улсын төсөв | Хамтарсан шинжээчдийн багийн протокол. Бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөгөөний протокол | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Хамтарсан шинжээчдийн багийн 2025-2026 оны ажлын төлөвлөгөөг баталсан протокол-1 үйлдсэн байна. | 1.Хилийн усыг хамгаалах, ашиглах, Засгийн газрын хоорондын хэлэлцээр, Хилийн усны ажлын хэсэг, шинжээчдийн багийн уулзалтыг зохион байгуулах ажлаар Усны газрын дарга Юнеско-гийн дэлхийн өвийн хорооны 46 дугаар чуулганд Бүгд Найрамдах Энтхэг улсын Нью Дели хотноо 2024.07.21-07.31-ны хооронд хилийн усны хэлэлцээрийн асуудлаар оролцсон. 2. ОХУ-ын Москва, Эрхүү хотноо 2024.08.24-08.29-ний хооронд зохион байгуулагдах ээлжит Хилийн усыг хамгаалах ашиглах тухай Монгол улс, ОХУ-ын засгийн газар хоорондын хэлэлцээрийн уулзалтанд Монголын талын төлөөлөгчөөр оролцсон. 3.Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хамтарсан ажлын хэсгийн хуралдааныг 12 дугаар уулзалтыг 2024 оны 09 дүгээр сарын 19-21-ний өдрүүдэд Монгол Улсын Улаанбаатар хотод зохион байгуулсан, Монголын талын шинжээчдийн багийн ахлагчаар Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын дарга З.Батбаяр, Хятадын талын шинжээчдийн багийн ахлагчаар Хятадын шинжээчдийн багийн дарга Усны нөөцийн яамны Усны нөөц, усны эрчим хүч төлөөлөлт, зураг төслийн ерөнхий хүрээлэнгийн дэд ерөнхийлөгч Ли Юань Юань нар ажилласан. 4.Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хамтарсан шинжээчдийн ажлын хэсгийн хуралдааныг 2024 оны 9-р сарын 27-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Монголын талын оролцогчдыг Монгол Улсын Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн орлогч, Монгол Улсын Усны газрын дарга З. Батбаяр, Оросын Холбооны талын оролцогчдыг Оросын Холбооны Улсын Засгийн газрын Бүрэн эрхт төлөөлөгчийн орлогч С.В. Калустин нар тус тус ахалж оролцсон. | 100 |

| | | | | | | | | |
|----|---|-------|-------------|--|-----------------------------------|---|---|-----|
| 54 | Арга хэмжээ 12.2.Усны үндэсний зөвлөлийн хуралдааны зохион байгуулах | 2.5 | Улсын төсөв | Зөвлөлийн хуралдааны тоо | 1 | Усны үндэсний зөвлөлийн хуралдааны зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, зөвлөлийн гишүүдийн холбогдох мэдээллээр хангаж ажиллана. | "Усны үндэсний зөвлөл"-ийн 2023 оны төлөвлөгөөний биелэлттэй танилцан 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд оруулах саналыг БОУАӨЯ-ны ЕНБХГ-т цахимаар хүргүүлсэн. "Усны үндэсний зөвлөл"-ийн хуралдааныг зохион байгуулах ажлын бэлтгэл ажлыг хангах хүрээнд БОАЖ сайдын 2024 оны А/47 дугаар тушаалаар 2.5 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн хуралдаан зохион байгуулах бэлтгэлийг бүрэн ханган ажиллаж байна. | 90 |
| 55 | Арга хэмжээ 12.3.Усны нөөц түүнийг зохистой хамгаалах, ашиглах чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах төслийн санал боловсруулж шинэ төсөл, хөтөлбөр эхлүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллах | - | - | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | 3-5 олон улсын байгууллага, элчин сайдын яам, төсөл хөтөлбөрт хамтран ажиллах санал хүргүүлсэн байна. | Усны нөөц түүнийг зохистой хамгаалах, ашиглах чиглэлээр олон улсын байгууллагатай хамтран ажиллах хүрээнд Усны газрын дарга нийт 11 удаагийн арга хэмжээнд оролцсон байна. Үүнд: 1.Швейцарын Холбооны Улсын Женев хотод 2024 оны 2 дугаар сарын 26-28 өдрүүдэд Хил дамнансан усны сав газрын асуудлаар, 2.ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооны 46 дугаар хуралдаанд 2024 оны 7-р сарын 21-31-ний өдрүүдэд Энэтхэгийн Нью-Дели хотноо 3.Оросын Холбооны Улсын Москва хотноо 2024 оны 8 дугаар сарын 24-29-ний өдрүүдэд хотод зохион байгуулагдах "Хилийн усны хэлэлцээрийн асуудал"-аар оролцох хуралд 4.Бүгд Найрамдах Индонез Улсын Бали аралд 2024 оны 05 дугаар сарын 18-25 өдрүүдэд зохион байгуулагдах Дэлхийн усны 10 дугаар форумд (World Water Forum) 5.Бүгд Найрамдах Словени Улсын Любляна хотноо Хил дамнансан гол горхи, олон улсуудын нууруудыг хамгаалах, ашиглах тухай конвенц (усны конвенц) -ын оролцогч талуудын 10 дугаар хуралдаанд 6 .Орось Холбооны Улсын Москва хотноо 2024 оны 10 дугаар сарын 08-12-ны өдрүүдэд "Хилийн усны хэлэлцээрийн асуудал"-аар хуралд 7.Бүгд Найрамдах Филиппин Улсын Манила хотноо 2024 оны 9 дүгээр сарын 17-18 өдрүүдэд зохион байгуулагдах "Уур амьсгалын нөхцөлд дасан зохицох хөрөнгө оруулалт төлөвлөлт"-ийн форумд 8.Европын Холбооны эдийн засгийн комиссын Нарийн бичгийн дарга нарын газартай Хилийн ус болон олон улсын нууруудыг хамгаалах, ашиглах тухай конвенцийн ойлголтын танилцуулга цахим журлыг 2024 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Усны газрын хурлын танхимд зохион байгуулсан. 9.Ази Номхон Далайн Усны хомсдолын хөтөлбөр (АНХДУХХ)-ийн хүрээнд Монгол дахь оролцогч талуудтай хийх зөвлөлдөх уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Усны газрын хурлын танхимд зохион байгуулсан. Мөн дээр дурдсан хилийн улсны 2 удаагийн хуралдааныг Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. | 100 |
| 56 | Арга хэмжээ 12.4.Олон нийтийн устай холбоотой хэвшмэл ойлголтыг өөрчлөх, хууль тогтоомжтой холбоотой асуудлыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах | 400.0 | Улсын төсөв | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, үер, усны аюул, болашгүй эрсдэлээс сэргийлэх, байгаль орчноо хамгаалах чиглэлээр сурталчилгааны ажил зохион байгуулах. | Дэлхийн усны өдрийн тохиолдуулан "Цэнхэр тууз" аяныг 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдөр эхлүүлж 2024 оны 06 дугаар сарын 22-ыг дуустал зохион байгуулахаар төлөвлөсөн.Тайлант хугацаанд хот хөдөөгийн 3 их дээд сургуулийн 200 гаруй оюутнууд, Ерөнхий боловсролын 124 сургуулийн 12,584 сурагч, Сургуулийн өмнөх боловсролын 2595 хүүхэд, 938 гаруй цэцэрлэгийн багш болон төрийн албан хаагчдад хамрагдсан байна. Арга хэмжээний хүрээнд "Усны нөөцийн нэгдсэн менежмент – талуудын оролцоо форум"-ыг 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдөр, Монгол орны усны нөөцийг бохирдож, хомсдохоос хамгаалах, үер уснаас сэргийлэх, зохистой ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэхэд төрөөс баримтлах бодлого, төлөвлөгөөг иргэд болон нийт, бүх шатны байгууллагуудад таницуулах зорилгоор нэгдсэн чуулганыг 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр тус тус зохион байгуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллалаа. | 100 |
| 57 | Арга хэмжээ 12.5.Усны газрын веб сайтад хууль, тогтоомж, байгууллыг үйл ажиллагаа болон усны талаарх мэдээ, мэдээллийг шинэчлэн оруулах | - | - | Байгууллагын веб сайтад байршуулсан мэдээллийн тоо | Сар бүр тогтмол зохион байгуулдаг | Сайтад байршуулсан мэдээлэл жилийн дүнгээр 24-өөс дээш байна. | Усны газар нь олон нийтэд www.water.gov.mn цахим хаяг болон нийгмийн сүлжээний "Усны газар" face book цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагаа, ажил, арга хэмжээг сурталчилж байна. 2024 онд Усны газар нийгмийг сүлжээнд оруулсан 52 удаагийн мэдээллийг 475.9 мянган удаа үзэж сонирхсон байна. Цахим хуудсанд байршуулсан мэдээллүүдийг байнга шинэчлэн гаргадаг. Мөн Дэлхийн Усны өдөрт зориулсан үйл ажиллагааны мэдээлэл, Гүнээсээ хайрлах уралдааны голц мэдээллүүдээр цахим хуудсаа баяжуулсан болно. 2024 оны 10 сараас эхлэн цахим сүлжээнд байгууллагын Виртуал хөтөлгөч болох "Merenган-MG"-гээр дамжуулан олон нийтэд хандсан мэдээллүүдийг оруулж байна. | 100 |

Зорилт 13: Төрийн байгууллагын уялдаа холбоо, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангаж, шийдвэр гаргагчдыг мэдээ, мэдээллээр хангах.

| | | | | | | | | |
|----|---|---|---|----------------------------------|-----------------------------------|--|--|-----|
| 56 | Арга хэмжээ 13.1.Дээд шатны байгууллага, албан тушаалтнаас байгууллагын үйл ажиллагаандаа дагаж мөрдүүлэхээр ирүүлсэн дүрэм, журам, тогтоол, шийдвэр, ажлын чиглэл, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | - | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Сар бүр тогтмол зохион байгуулдаг | Биелэлтийн хариуг 100 хувь хүргүүлж, хэрэгжилтийн үр дүнг 80 хувиас дээш хэрэгжүүлсэн байна. | "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсын Засгийн газрын (2020-2024 оны) 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилт, арга хэмжээний төлөвлөгөө, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан 21 чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ажлын тайланг сар бүр БОУАӨЯ-д тайлагнаж хүргүүлсэн. Мөн БОУАӨ сайдын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 02 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах хүрээнд сав газруудын захиргаадыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан. | 100 |
| 59 | Арга хэмжээ 13.2.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан нийтлэг журмын дагуу Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлнэ. | - | - | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна. | Хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдэд хяналт-шинжилгээ хийж, Байгаль орчин аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. 2024 онд шинээр Засгийн газрын тогтоол-4, Ерөнхий сайлын захирамж-1, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл-5 ирүүлснийг албан хаагчдад танилцуулан хамаарах заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100 |
| 60 | Арга хэмжээ 13.3.Агентлаг болон сав газрын захиргаадын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, Үндэсний аудитын газраас ирүүлсэн акт, албан шаардлагын хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх. | - | - | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | - | Сав газруудын санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод аудитын төлөвлөгөөний хуваарийн дагуу 100 хувь дотоод аудит хийж, санал, дүгнэлт, зөвлөмж хүргүүлсэн байна. | Усны газар болон сав газруудын захиргаадын үйл ажиллагаанд "Дотоод аудитын ажлын баримт: "АБ1005" хүрээнд эрсдэлийн урьдчилсан үнэлгээ хийж дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөөнд холбогдох хэлтсүүдээс санал авч боловсруулж "Дотоод аудитын дунд хугацааны төлөвлөгөө" боловсруулж агентлагийн даргын тушаалаар батлуулсан. Усны газар болон сав газруудын захиргаадын үйл ажиллагаанд Үндэсний аудитын газар болон хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагаас ирүүлсэн акт, албан шаардлага, дүгнэлт зөвлөмжийн биелэлтийг "Төрийн аудитын тухай" хуульд заасны дагуу төлөвлөгөө гаргаж Үндэсний аудитын газарт хүргүүлэх, хэрэгжилтийг хангаж ажиллахад хяналт тавьж батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Сав газруудын захиргаадаас иргэн аж ахуйн нэгж, байгууллагад гаргасан ус ашиглуулах дүгнэлт, холбогдох хууль дүрэм, журам, стандартын дагуу хийсэн байдлыг тулган баталгаажуулж, дотоод аудит хийж дүгнэлт зөвлөмж хүргүүлж илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна. 2024 оны байдлаар Туул голын сав газрын захиаргаа болон Хэрлэн, Хараа Ерөө, Бөөнцэвэр-орог нуур, Галба-өөш-долоодын говийн сав газрын захиаргаадаас гаргасан Ус ашиглуулах дүгнэлтэд газрын даргын баталсан дотоод аудитын удирдамжийн дагуу, дотоод аудит хийж байна. | 90 |

Зорилт 14: Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, хүний нөөцийн эрэлт, хэрэгцээний судалгаа хийх.

| | | | | | | | | |
|----|--|---|---|----------------------------------|-----------------------------------|--|--|-----|
| 61 | Арга хэмжээ 14.1.Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд хүний нөөцийн мэдээллийг оруулах, боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тогтмол шуурхай зохион байгуулах. | - | - | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Хүний нөөцийн мэдээллийг шинэчлэх, хүний нөөцтэй холбоотой хууль, тогтоомж, гушаал, шийдвэрийн биелэлтийг хангуулах ажлыг бүрэн зохион байгуулсан байна. | Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлагын системд хүний нөөцийн мэдээллийг шинэчлэн боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг тухай бүрд нь шуурхай зохион байгуулсан. 2024 онд нийт 18 албан хаагчийн шилжилт хөдөлгөөн хийгдсэнээс 10 албан хаагчийг ажилд томилж, 2 албан хаагч тэтгэвэр тогтоолгож, 5 албан хаагчийг ажлаас чөлөөлж, хүүхэд асрах чөлөө олгосон 1 байна. | 100 |
|----|--|---|---|----------------------------------|-----------------------------------|--|--|-----|

| | | | | | | | | |
|----|--|---|---|--|-----------------------------------|---|---|------|
| 62 | Арга хэмжээ 14.2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх | - | - | Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Хөтөлбөр төлөвлөгөөнд заасан арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж гүйцэтгэл 80-аас дээш хувьтай байна. | Хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж, батлуулан холбогдох арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж биелэлт 80.6 хувийн биелэлттэй байна. | 95.8 |
| 63 | Арга хэмжээ 14.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй, шударга ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгоход чиглэсэн ажлын байран дахь сургалтыг зохион байгуулна. | - | - | Хууль, тогтоомжийг хэрэгжилтийг хангуулж ажилласан гүйцэтгэлийн хувь | Жил бүр тогтмол зохион байгуулдаг | Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр нийт албан хаагчдад дотоодын сургалтыг зохион байгуулсан байна. | Авлигын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн талаар АТГ-аас гаргасан цахим сургалтыг байгууллагын дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад сургалтыг зохион байгуулсан. Удирдлагын академиас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал" хэлэлцүүлэг сэтгэлгээний өөрчлөлт сургалтад 2024.05.27-нд 10 албан хаагч хамруулсан. Тагнуулын ерөнхий газарт санал хүргүүлэн төрийн нууцын талаар 2024.04.03-ны өдөр нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ", Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг байгууллагын дотоод цахим шуудангаар нийт албан хаагчдад танилцуулан, сурталчлах ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 64 | Арга хэмжээ 14.4. Ёс зүйн хариуцлага хүлээсэн төрийн албан хаагчийг танхимын дагтан сургалтад хувийн зардлаар хамруулна. | - | - | Сургалтад хамруулсан хувь | - | Ёс зүйн хариуцлага хүлээсэн албан хаагч бүрийг хувийн зардлаар нь ёс зүйн сургалтад хамруулсан байна. | 2024 онд албан хаагчидтай холбоотой ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл ирээгүй буюу ёс зүйн зөрчил гаргаж, ёс зүйн хариуцлага хүлээсэн албан хаагч байхгүй болно. | 100 |
| 65 | Арга хэмжээ 14.5. Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу зохион байгуулж, ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон зөрчлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - | - | Эрсдэлийн тооцох үнэлгээ хийгдсэн эсэх | - | Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээг хийж, ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөлийг судалж тогтоосон байна. | Албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцоож, тогтоон Төрийн албаны тухай хууль, "Авлигын эсрэг хууль" болон "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн холбогдох зүйл заалтуудыг мөрдөж ажиллах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар 2024 оны 03 дугаар сарын 12-оос 14-ний өдрүүдэд албан хаагчдаас бичгээр баталгаа гаргуулан авсан зэрэг ажлуудыг зохион байгуулсан. Архив, албан хэрэг хөтөлөлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд ирүүлсэн нийт албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийж байгууллагын даргад уламжилсны дагуу Усны газрын даргын даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн "Архив, албан хэрэг хөтөлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах тухай" А/136 дугаар тушаал гарсан. Албан хаагчдын авлигаас урьдчилан сэргийлэх ёс зүйг төлөвшүүлэх хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүнд "Эм эс бэл майнинг" ХХК-иас 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр мэргэжилтэнд авлига өгөх оролдлого хийсэн үйлдлийг таслан зогсоож танай байгууллагын 110 дугаарын утсаар мэдээлэл өгсний дагуу одоо эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгагдаж байгаа болно. | 100 |
| 66 | Арга хэмжээ 14.6. Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг биелүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн үйл ажиллагаа, Ёс зүйн дэд хорооны ажлын тайланг олон нийтэд мэдээлнэ. | - | - | Тайланг байгууллагын веб сайтад байршуулж олон нийтэд мэдээлсэн эсэх | - | Тайланг байгууллагын веб сайтад байршуулсан байна. | Усны газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/13 дугаартай тушаалаар "Ёс зүйн дэд хороо"-г 5 гишүүнтэй байгуулав. Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тушаалаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д нийлүүлэн Усны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/166 дугаар тушаалаар "Ёс зүйн дэд хороо"-г 3 гишүүнтэй байхаар шинэчлэн баталж, Ёс зүйн дэд хорооны ажлын төлөвлөгөөг батлан, улирал бүрийн тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэн, мэдээллийг байгууллагын веб сайт цахим хуудаст байршуулсан. | 100 |

Зорилт 15: Төсөв, санхүү, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах

| | | | | | | | | |
|----|--|---|---|--|-----------------------------------|---|--|-----|
| 67 | Арга хэмжээ 15.1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах | - | - | Тайлангуудыг тухай бүрт нь тайлагнасан байх | Сар бүр тогтмол зохион байгуулдаг | Сая газрын захиргаадн санхүүгийн тайланг 2024 оны хагас жилээр нэгтгэж, харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж нэгтгүүлсэн байна. | Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу 2024 оны 3 сарын 1-нд Үндэсний аудитын газарт хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 сарын 25-нд төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж нэгтгүүлсэн. | 100 |
| 68 | Арга хэмжээ 15.2. Агентлагийн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах | - | - | Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан хувь | Сар бүр тогтмол зохион байгуулдаг | Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангаж ажигласан байна. | Тус газрын 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд "Усны нөөц, гол мөрний менежментийн хөтөлбөр"-ийн хүрээнд 36 нэр төрлийн 3,447,206.1 мянган төгрөгийн, Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд 4 нэр төрлийн 9,841,300.0 мянган төгрөгийн ажлууд хийгдэхээр төлөвлөгөө батлагдсан. Одоогийн байдлаар хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах ажил нь хууль тогтоомжийн дагуу явагдаж байна. Үүнээс 11 тендер зарласнаас 11 тендрийг шалгаруулж гэрээ байгуулсан. Тендер сонгон шалгаруулалтгүйгээр буюу шууд худалдан авах ажиллагааны аргаар 29 худалдан авах ажиллааг зохион байгуулсан. | 100 |
| 69 | Арга хэмжээ 15.3. Агентлагийн ажилчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тайлагнах | - | - | Тайлангуудыг тухай бүрт нь тайлагнасан байх | Сар бүр тогтмол зохион байгуулдаг | Агентлагийн ажилчдын цалин, тэтгэмжийг бодож олгох, нийгмийн даатгалын шимтгэл, хүн амын орлогын албан татварын тайлангуудыг тухай бүрд нь тайлагнасан байна. | Тус газрын албан хаагчдын сарын цалинг сар бүрийн 10, 20-нд 2 удаа төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системийн цалингийн програмаар бодож ахлах нягтлан бодогчоор тухай бүр хянуулан шалгуулж, гарын үсгээр батлаагаажуулж албан хаагчдын цалинг хугацаанд нь олгож ажиллалаа. Албан хаагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлогоос хуульд заасан хувиар албан татвар ногдуулж ахлах нягтлан бодогчоор тооцож хянуулан Баянгол дүүргийн Татварын хэлтэст татварыг бүрэн шилжүүлсэн. 2024 онд Нийгмийн даатгалын цаасан болон цахим тайланг ахлах нягтлан бодогчоор хянуулан сар бүрийн 4-ний дотор Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хуулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан. Тайланг хугацаанд нийт 11 удаа нийгмийн даатгалын тайлан гаргаж 36 албан хаагчаас 06-хүүхэд асрах чөлөөтэй эх-1, тэтгэвэрийн насны албан хаагч 2, албан хаагч 33 ажилчдын цалингаас даатгуулагч болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож Нийгмийн даатгалын хэлтэст шимтгэлийг бүрэн төлж ажилласан. | 100 |

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ

Зорилт 16: Төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг шийдвэрлэх.

| | | | | | | | | |
|----|---|---|---|---|--|---|---|-----|
| 70 | Арга хэмжээ 16.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн албан бичиг, хүсэлтийн хариуг хуулийн хугацаанд түргэн, шуурхай шийдвэрлэх ажлын үр дүнг сайжруулах. | - | - | Ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх хугацаа | Хууль, тогтоомжид зааснаар 7-30 хоногт шийдвэрлэнэ | Жилд дунджаар 13-аас цөөн хоногт шийдвэрлэж хариуг хүргүүлж, нийт албан бичгийн бүртгэл хөтөлсөн байна. | 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар ирсэн бичиг 1413, явуулсан бичиг 1210, өргөдөл, гомдол бүхий 28 албан бичгийн цахим архив үүсгэсэн. Үүнээс ирсэн 1262 албан бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, 141 албан бичиг хариу өгөхөөр судлагдаж байгаа буюу нийт ирсэн албан бичгийн шийдвэрлэлт 89,3 хувьтай байна. Нийт албан бичгийн хариутай 552 албан бичгийг шийдвэрлэлтийг хугацаагаар нь авч үзвэл 12,9 хоногт шийдвэрлэсэн байна. | 100 |
| 71 | Арга хэмжээ 16.2. Төрийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд, түргэн шуурхай шийдвэрлэж хариуг хүргүүлэх. | - | - | Ирүүлсэн өргөдөл, гомдлыг түргэн шуурхай шийдвэрлэх хугацаа | Хууль, тогтоомжид зааснаар 30 хоногт шийдвэрлэнэ | Жилд дунджаар 13-аас цөөн хоногт шийдвэрлэж хариуг хүргүүлж, нийт албан бичгийн бүртгэл хөтөлсөн байна. | 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар иргэд аж ахуйн нэгж байгууллагаас 28 удаагийн өргөдөл, гомдол ирсэнийг хүлээн авч 28 өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байна. Эдгээр өргөдөл, гомдлуудыг төрлөөр авч үзвэл 17 өргөдөл, 11 хүсэлт ирүүлснээс өргөдөл, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж дунджаар 11,3 хоногт шийдвэрлэсэн байна. | 100 |

| | | | | | | | |
|---------------------------------------|---|----------|---|-------------------------------|--|--|------|
| 72 | Арга хэмжээ 16.3. Агентлагийн үйл ажиллагаанд хуулиар хориглоогүй мэдээллийг олон нийт, иргэдэд ил тод, нээлттэй байлгах, мэдээлэл авах эрх тэгш боломжоор хангах | | Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудын холбогдох заалтын дагуу оруулсан мэдээний тоо | Нийт 159 мэдээллийг оруулсан. | Байгууллагын болон ажиллагсдын мэдээлэл, худалдан авалтын мэдээллийг тухай бүр 8, сар бүр 3, улиралд 34, хагас жилд 79, бүтэн жилд 159 мэдээлэл цаг хугацаанд нь оруулсан байна. | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан " Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай" журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухайн хууль журмын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан Усны газрын даргын тушаалаар батлуулан ажиллаж байна. Шилэн дансны мэдээллийг тухай бүр 8, сар бүр 3, улиралд 34, хагас жилд 79, бүтэн жилд 159 мэдээлэл цаг хугацаанд нь оруулсан байна. | 100 |
| Нийт хэрэгжүүлэх арга хэмжээний төсөв | | 29,696.2 | Нийт 16 зорилтын хүрээнд 72 арга хэмжээний биелэлт | | | | 96.9 |

Хавсралтаар: Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийг хавсаргав.

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН: Төсвийн Ерөнхийлөн захирагч
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

С.ОДОНТУЯА

2024 оны сарын

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.БУЯННЭМЭХ

2024 оны сарын

ТӨЛӨВЛӨГӨӨГ ТАЙЛАГНАСАН: Төсвийн Шууд захирагч
УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

2024 оны сарын